

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

Аудитын код: ОРА-2026/031/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг:
ppurevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: “Төгс нотолгоо аудит” ХХК-ийн Ахлах аудитор:
Г.Цэцэгмаа
Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.24 № 74
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 181,573.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсан ба санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд спортын заалны 8,444.5 мянган төгрөгийн орлогыг бүртгэл тайланд тусгаагүй,
- Байгууллагын бүтэц орон тоонд хамаарахгүй иргэнийг ажилд авч, 25,875.9 мянган төгрөгийн цалин олгосон,
- Тайлант онд нярвын орон тоог нэмж 16,601.4 мянган төгрөгийн цалин олгосон,
- Тайлант онд 4 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 3,485.6 мянган төгрөг илүү олгосон,
- Зардлын зүйл анги зөрчиж 2,010.0 мянган төгрөг зарцуулсан,

612505412

- Кассаас зарцуулсан 2,800.0 мянган төгрөгийг бүртгэл тайланд тусгаагүй,
- Хичээлийн хэрэглэгдэхүүнд ашиглагдахгүй энгэрийн микрофон, камер гэрэлтүүлэгчийг зах зээлийн ханшаас өндөр үнэтэй бэлтгэсэн,
- Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын хөрөнгийн тооллогын дүн нягтлан бодох бүртгэлийн хөрөнгийн дүнгээс 24,462.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тоологдсон,
- Эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлээс 6,685.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Хоол үйлдвэрлэлийн орлогоос анхан шатны нотлох баримтгүй 464.2 мянган төгрөгийг бэлнээр зарцуулсан,
- Хүнсний материалын 874.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Нягтлан бодох бүртгэлийн хүнсний материалын эцсийн үлдэгдэл нярвын тайлангийн үлдэгдлээс 1,056.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, эд хариуцагчийн хүнсний материалын эцсийн үлдэгдэл нягтлан бодох бүртгэлийн үлдэгдлээс 1,150.2 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улс Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралт "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд "Гүүд Нейборс" ОУТББ, "Хасу Инженеринг" ХХК-тай сэтгэл зүйн ерөөний засвар тохижилтын ажлын гурвалсан гэрээ байгуулсан байна. Тохижилтын ажлыг гүйцэтгэгч тал хийж дуусгасан боловч ажил хүлээлцсэн акт үйлдэж, хөрөнгийг хүлээн авч, бүртгэл тайланд тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Боловсролын салбарын байгууллагууд 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 13 хоногийн ажил хаялтад нэгдэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 30.3-т "Ажил хаялтад оролцоогүй боловч түүнээс шалтгаалан ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй байсан ажилтанд тухайн хугацаанд дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч олгоно" гэж заасны дагуу цалин хөлсөө авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг тайлант онд үнэлүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг

буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

ХОЁР . АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>659,857,332.39</u>	<u>736,148,036.84</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	489,764,501.26	522,880,124.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	489,764,501.26	522,880,124.55
3121	Төгрөг	489,764,501.26	522,880,124.55
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31212	Монгол банкин дахь харилцах	489,764,501.26	522,880,124.55
31213	Арилжааны банк дахь харилцах		
33	АВЛАГА	1,618,979.90	1,618,979.90
335	Бусад авлага	1,618,979.90	1,618,979.90
3351	Байгууллагаас авах авлага	1,618,979.90	1,618,979.90
35	БАРАА МАТЕРИАЛ	168,473,851.23	211,648,932.39
351	Түүхий эд материал	78,071,611.68	94,826,001.68
35110	Тусгай зориулалттай материал	77,586,611.68	94,261,811.68
35130	Эм боох материал	485,000.00	564,190.00
354	Хангамжийн материал	90,402,239.55	116,822,930.71
35410	Бичиг хэргийн материал	3,807,312.50	3,477,193.50
35420	Аж ахуйн материал	3,115,838.00	9,525,212.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	1,933,405.00	-
35450	Барилгын засварын материал	-	3,181,480.00
35460	Хүнсний материал	458,480.00	754,660.00
35470	Бусад хангамжийн материал	81,087,204.05	99,884,385.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,875,141,635.57</u>	<u>4,038,968,516.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,875,141,635.57	4,038,968,516.41
391	Газар		
392	Биет хөрөнгө	3,476,061,635.57	3,641,088,516.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,168,066,341.88	3,441,085,135.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(359,057,505.99)	(424,576,784.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,000,000.00)	(40,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	533,441,582.54	580,159,548.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(190,470,143.07)	(289,211,383.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	296,686,420.60	288,706,813.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(98,355,389.42)	(125,931,118.00)
39209	Зам, гүүрийн байгууламж	180,175,786.33	248,426,520.33
39210	Хуримтлагдсан элэгдэл	(54,425,457.30)	(77,570,216.04)
393	Биет бус хөрөнгө	399,080,000.00	397,880,000.00
39301	Програм хангамж	8,662,784.00	8,662,784.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,862,784.00)	(8,062,784.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	397,280,000.00	397,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,534,998,967.96</u>	<u>4,775,116,553.25</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>874,270.00</u>	<u>1,685,470.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	874,270.00	1,685,470.00
413	Өглөг	874,270.00	1,685,470.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	874,270.00	874,270.00
4136	Бусад өглөг	-	811,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	811,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,534,124,697.96</u>	<u>4,773,431,083.25</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,534,124,697.96	4,773,431,083.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,493,834,578.34	1,493,834,578.34

51101	Өмч: - төрийн	1,493,834,578.34	1,493,834,578.34
512	Хуримтлагдсан үр дүн	683,324,114.99	922,630,500.28
51210	Өмнөх үеийн үр дүн	683,324,114.99	683,324,114.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	239,306,385.29
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,356,966,004.63	2,356,966,004.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,534,998,967.96</u>	<u>4,775,116,553.25</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,504,875,235.00	3,473,285,199.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	225,361,735.00	692,963,199.92
120	Нийтлэг татварын бус орлого	225,361,735.00	692,963,199.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	225,361,735.00	291,857,161.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,588,900.00	5,009,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	219,772,835.00	286,847,461.76
120009	Бусад орлого	-	29,739,970.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		338,908,887.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		32,457,181.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,279,513,500.00	2,780,322,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,174,566,700.00	2,673,889,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,174,566,700.00	2,673,889,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,946,800.00	106,432,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,946,800.00	106,432,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,559,639,686.06	3,233,978,814.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,559,639,686.06	3,233,978,814.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,443,668,654.25	3,084,743,454.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,732,190,283.00	2,298,509,113.45
210101	Үндсэн цалин	1,126,122,836.00	1,231,936,927.96
210102	Нэмэгдэл	541,778,818.00	946,938,398.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,085,059.00	67,854,410.44
210104	Урамшуулал	61,203,570.00	51,779,376.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,326,771.89	279,322,287.89
210201	Тэтгэврийн даатгал	144,879,094.46	190,942,129.52
210202	Тэтгэмжийн даатгал	17,405,125.44	23,196,543.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,102,236.64	12,146,825.84
210204	Ажилгүйдлийн даатгал	7,750,283.04	10,891,747.93
210205	Эрүүл мэндийн даатгал	31,190,032.31	42,145,041.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,241,358.19	74,789,500.16
210301	Гэрэл, цахилгаан	17,880,383.43	22,676,763.94
210302	Түлш, халаалт	34,064,332.65	35,654,104.69
210303	Цэвэр, бохир ус	12,296,642.11	16,458,631.53
2104	Хангамж, бараа материалын зардал	708,729.00	26,388,372.50
210402	Тээвэр, шатахуун	-	7,693,405.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	18,694,967.50
210408	Бараа материал акталсны зардал	708,729.00	-
2105	Нормативт зардал	44,453,700.00	19,131,970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	155,970.00
210502	Хоол, хүнс	44,453,700.00	18,976,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,985,850.00	19,818,000.00
210604	Урсгал засвар	25,985,850.00	19,818,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,089,054.03	42,552,181.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,890,300.00	5,090,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,198,754.03	37,461,981.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	339,672,908.14	324,232,029.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,897,283.63	90,739,424.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,877,700.00	17,311,599.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,897,924.51	216,181,006.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,971,031.81	149,235,359.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,684,390.00	140,591,540.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	102,684,390.00	140,591,540.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,286,641.81	8,643,819.84
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,286,641.81	8,643,819.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(54,764,451.06)	239,306,385.29
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(54,764,451.06)	239,306,385.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,504,875,235.00	3,072,179,161.76
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	225,361,735.00	291,857,161.76
120	Нийтлэг татварын бус орлого	225,361,735.00	291,857,161.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	225,361,735.00	291,857,161.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,588,900.00	5,009,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	219,772,835.00	286,847,461.76
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,946,800.00	106,432,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,946,800.00	106,432,800.00
2105	Нормативт зардал	44,453,700.00	18,976,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	44,453,700.00	18,976,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,418,800.00	22,999,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	27,418,800.00	22,999,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,389,054.03	42,552,181.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,890,300.00	5,090,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,498,754.03	37,461,981.13
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,293,902.60	111,284,436.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,366,202.60	97,901,056.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,927,700.00	13,383,380.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,555,241.81	149,531,539.84

2132	Бусад урсгал шилжүүлэг	102,268,600.00	140,887,720.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	102,268,600.00	140,887,720.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,286,641.81	8,643,819.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,286,641.81	8,643,819.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>149,383,917.26</u>	<u>74,214,623.29</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,960,000.00	41,099,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,960,000.00	41,099,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,960,000.00	41,099,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,960,000.00	41,099,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,960,000.00)</u>	<u>(41,099,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	147,423,917.26	33,115,623.29
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		489,764,501.26
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	489,764,501.26	522,880,124.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	683,324,114.99	4,534,124,697.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	683,324,114.99	4,534,124,697.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	238,345,717.19	238,345,717.19
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	683,324,114.99	4,534,124,697.96
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	683,324,114.99	4,534,124,697.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	683,324,114.99	4,534,124,697.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	239,306,385.29	239,306,385.29
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	922,630,500.28	4,773,431,083.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,473,837,400.00	3,030,419,718.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,473,837,400.00	2,989,320,718.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,347,049,200.00	2,848,432,998.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,711,037,200.00	2,298,509,113.45
210101	Үндсэн цалин	1,485,526,200.00	1,190,124,701.96
210102	Нэмэгдэл	1,197,941,000.00	988,750,624.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	67,854,410.44
210104	Урамшуулал	27,570,000.00	51,779,376.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	339,080,900.00	279,322,287.89
210201	Тэтгэврийн даатгал	230,575,000.00	190,989,879.31
210202	Тэтгэмжийн даатгал	27,126,400.00	23,056,518.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,563,300.00	12,146,825.84
210204	Ажилгүйдлийн даатгал	13,563,300.00	11,031,772.97
210205	Эрүүл мэндийн даатгал	54,252,900.00	42,097,291.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,432,800.00	74,789,500.16
210301	Гэрэл, цахилгаан	22,458,800.00	22,676,763.94
210302	Түлш, халаалт	47,801,500.00	35,654,104.69
210303	Цэвэр, бохир ус	13,172,500.00	16,458,631.53
2105	Нормативт зардал	24,676,000.00	18,976,000.00
210502	Хоол, хүнс	24,676,000.00	18,976,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,000,000.00	22,999,480.00
210604	Урсгал засвар	23,000,000.00	22,999,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,489,200.00	42,552,181.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,198,600.00	5,090,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	44,290,600.00	37,461,981.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,333,100.00	111,284,436.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,356,100.00	97,901,056.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,977,000.00	13,383,380.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,788,200.00	140,887,720.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	126,788,200.00	140,887,720.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	126,788,200.00	140,887,720.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	41,099,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	41,099,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	41,099,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,076,135,100.00	3,072,179,161.76
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,669,573,000.00	2,673,889,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,669,573,000.00	2,673,889,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,432,800.00	106,432,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	106,432,800.00	106,432,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,129,300.00	291,857,161.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,198,600.00	5,009,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	291,930,700.00	286,847,461.76
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		489,764,501.26
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		522,880,124.55
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	149.00	144.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	99.00	97.00
620003	Үйлчлэх ажилтан	48.00	45.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	75.00	72.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	46.00	45.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2.00	2.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26.00	24.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,466.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 11,466.6 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайлангаар хоолны зардлыг 11,466.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС 1 болон толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн тайлангийн аудитаар залруулав.

Аудитаар нийт 154,180.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 5,064.6 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 143,909.7 мянган төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 5,206.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант онд 4 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 3,485.6 мянган төгрөг илүү олгосон, сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байхад 8 дугаар сард албан хаагчид 757.6 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон, хоол үйлдвэрлэлийн орлогоос 464.2 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүй бэлнээр зарцуулсан, спортын заалны орлого 357.2 мянган төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд тушаагүй зөрчлүүдэд 4 төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 143,909.7 мянган төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Тайлант онд спортын заалны орлого 8,444.5 мянган төгрөгийг урсгал засвар, мэдээлэл технологийн зардал, нөхөн хангалтын зардалд бэлнээр шууд зарцуулсан байна.
- Тус сургууль нь “Гүүд Нейборс” ОУТББ, “Хасу Инженеринг” ХХК-тай сэтгэл зүйн өрөөний засвар тохижилтын ажил хийхээр 32,903.2 мянган төгрөгийн гурван талт гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна. Сэтгэл зүйн өрөөний тохижилтын ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дуусаж, 8 сар өнгөрсөн хэдий ч ажил хүлээлцсэн акт үйлдэж, хөрөнгийг орлогоор бүртгээгүй байна.
- Бага ангийн 18 багш, 1 хоол зүйч хоолны нөхөн олговор авсан хэдий ч 7,047.0 мянган төгрөгийн сурагчдын үдийн хоолонд хамрагдсан байна.
- Байгууллагын бүтэц орон тоонд батлагдаагүй тусгай хэрэгцээт боловсролын арга зүйчийг захирлын тушаалаар томилж, тайлант онд 25,875.9 мянган төгрөгийн цалин олгосон байна.
- Тайлант онд сургуулийн захирал нь байгууллагын бүтэц, орон тоог батлахдаа няравын орон тоог 2 албан тушаалтнаар гүйцэтгүүлэхээр тушаал гаргаж, илүү орон тооны няравт 16,601.4 мянган төгрөгийн цалин олгосон байна.
- Байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан хөрөнгийн дүнг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүнгээс 24,462.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.
- Эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлийн дүнгээс 6,685.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэр төрлийн тогоочийн тайлан гаргалгүйгээр худалдан борлуулах зорилгоор 21,899.5 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч, 26,345.5 мянган төгрөгийн хоол борлуулсны орлогыг харилцах дансандаа төвлөрүүлсэн байна.

- Эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлийн дүнгээс 6,685,400 (зургаан сая зургаан зуун наян таван мянга дөрвөн зуун) төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Байгууллагын 2025 оны санхүүгийн тайланг Төрийн аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлээгүй, анхан шатны баримт, материалыг аудиторын шаардсан хугацаанд өгөөгүй, аудитаар нийт 154,180.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил гаргаж, сөрөг санал дүгнэлт авсан Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн захирал С.Эрдэнэтогтоход хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага Орхон аймгийн боловсролын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэжаргалд хүргүүлсэн.
- Байгууллагын 2025 оны санхүүгийн тайланг Төрийн аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлээгүй, анхан шатны баримт, материалыг аудиторын шаардсан хугацаанд өгөөгүй, аудитаар нийт 154,180.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил гаргаж, сөрөг санал дүгнэлт авсан нягтлан бодогч А.Бадамхатанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн захирал С.Эрдэнэтогтоход хүргүүлсэн.
- Сургуулийн аж ахуйн нярав нь байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан хөрөнгийн дүнг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүнгээс 24,462.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, спортын заалны орлого 8,444.5 мянган төгрөгийг урсгал засвар, мэдээлэл технологийн зардал, нөхөн хангалтын зардалд бэлнээр шууд зарцуулж, албан үүргээ биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан нярав Ц.Алтанзулд хуульд заасны дагуу сахилгын ногдуулах албан шаардлага Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн захирал С.Эрдэнэтогтоход хүргүүлсэн.
- Сургуулийн хүнсний нярав нь тайлант онд хоол үйлдвэрлэлийн орлогын 464.2 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүй бэлнээр зарцуулсан, эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлийн дүнгээс 6,685.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж, албан үүргээ биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан нярав Э. Мөнхзулд хуульд заасны дагуу сахилгын ногдуулах албан шаардлага Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн захирал С.Эрдэнэтогтоход хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хичээлийн хэрэглэгдэхүүнд ашиглагдахгүй энгэрийн микрофон, камер гэрэлтүүлэгчийг 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөөр шаардлагагүй хөрөнгө бэлтгэхгүй байх

2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалын дансанд жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, нярвын тайланг санхүүгийн тайлангаас 2206.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; 20.2.3-т заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Хүнсний материалын бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайлангаар хоолны зардлыг 11,466.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан Санхүүгийн үр дүнгийн тайлангаар хоолны зардлыг 11,466.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	11,466.6			1	11,466.6	1	11,466.6				
Дүн	1	11,466.6			1	11,466.6	1	11,466.6				

ТАВ. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд спортын заалны орлого 357.2 мянган төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд тушаагүй	1	357.2	1	357.2								
Сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байхад 8 дугаар сард албан хаагчид 757.6 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон	1	756.6	1	756.6								
Хоол үйлдвэрлэлийн орлогоос 464.2 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүй бэлэнээр зарцуулсан	1	464.2	1	464.2								
Тайлант онд 4 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 3,485.6 мянган төгрөг илүү олгосон	1	3,485.6	1	3,485.6					-			

Тайлант онд спортын заалны орлого 8,444.5 мянган төгрөгийг урсгал засвар, мэдээлэл технологийн зардал, нөхөн хангалтын зардалд бэлнээр шууд зарцуулсан	1	8,444.5			1	8,444.5						
Тус сургууль нь “Гүүд Нейборс” ОУТББ, “Хасу Инженеринг” ХХК-тай сэтгэл зүйн өрөөний засвар тохижилтын ажил хийхээр 32,903.2 мянган төгрөгийн гурван талт гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна. Сэтгэл зүйн өрөөний тохижилтын ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дуусаж, 8 сар өнгөрсөн хэдий ч ажил хүлээлцсэн акт үйлдэж, хөрөнгийг орлогоор бүртгээгүй байна	1	32,903.2			1	32,903.2						
Бага ангийн 18 багш, 1 хоол зүйч хоолны нөхөн олговор авсан хэдий ч 7,047.0 мянган төгрөгийн сурагчдын үдийн хоолонд хамрагдсан байна.	1	7,047.0			1	7,047.0						
Тайлант онд сургуулийн захирал нь байгууллагын бүтэц, орон тоог батлахдаа няравын орон тоог 2 албан тушаалтнаар гүйцэтгүүлэхээр тушаал гаргаж, илүү орон тооны няравт 16,601.4 мянган төгрөгийн цалин олгосон	1	16,601.4			1	16,601.4						
Байгууллагын бүтэц орон тоонд батлагдаагүй тусгай хэрэгцээт боловсролын арга зүйчийг захирлын тушаалаар томилж, тайлант онд 25,875.9 мянган төгрөгийн цалин олгосон	1	25,875.9			1	25,875.9						
Байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан хөрөнгийн дүнг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүнгээс 24,462.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	24,462.8			1	24,462.8						
Эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлийн дүнгээс 6,685.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	6,685.4			1	6,685.4			-			
Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний нэр төрлийн тогоочийн тайлан гаргалгүйгээр худалдан борлуулах зорилгоор 21,899.5 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч, 26,345.5 мянган төгрөгийн хоол борлуулсны орлогыг харилцах дансандаа төвлөрүүлсэн байна.	1	21,899.5			1	21,899.5						
Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 154,180.8 мянган	1								4	4		

төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, аудитаар “Сөрөг” дүгнэлт өгсөн албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн сургуулийн захирал С.Эрдэнэтогтох, Нягтлан бодогч А.Бадамхатан Аж ахуйн нярав Ц.Алтанзул хүнсний нярав Э. Мөнхзул нарт хуулийн дагуу хариуцлага тооцох												
Хичээлийн хэрэглэгдэхүүнд ашиглагдахгүй энгэрийн микрофон, камер гэрэлтүүлэгчийг зах зээлийн ханшаас өндөр үнэтэй бэлтгэсэн	1	3,000.0					1	3,000.0				
Хүнсний материалын дансанд жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, нярвын тайланг санхүүгийн тайлангаас 2206.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	2,206.5					1	2,206.5				
Дүн	17	154,180.8	4	5,064.6	8	143,909.7	2	5,206.5	4	4		